



**ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ
ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2026 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/46

Улаанбаатар хот

Дотоод хяналтын албаны 2026 оны хяналт
шалгалтын төлөвлөгөө батлах тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг, Дотоод аудитын үйл ажиллагааг зохион байгуулах журмын 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэг, Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмын 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Дотоод хяналтын албаны хяналт шалгалтын 2026 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтийг хангаж ажиллахыг Дотоод хяналтын албаны дарга (Б.Батжаргал)-д үүрэг болгосугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан гүйцэтгэх захирлын 2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/07 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.


ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЛХАГВА-ОЧИР



1525000162

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн
гүйцэтгэх захирлын 2026 оны 04 дугаар
сарын 16 өдрийн 4/4 тушаалын хавсралт



ДОТООД ХЯНАЛТЫН АЛБАНЫ 2026 ОНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Дотоод аудитаар хийгдэх ажил	Хугацаа	Хамрах газар хэлтэс
1	Гүйцэтгэх захирлын тушаалаар байгуулагдсан дэд хороодын ажлын гүйцэтгэлд хяналт шалгалт хийх	I улиралд	Хамааралтай ажилтнууд
2	2025 онд хийгдсэн хяналт шалгалтаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг хянах, хэрэгжилтэд үнэлгээ өгөх	I улиралд	ХУАГ ТХГ
3	Түрээсийн гэрээтэй 592 иргэний барьцаа хөрөнгө, орлогын бүртгэлд хяналт шалгалт хийх	II улиралд	Хөрөнгийн удирдлага, ашиглалтын газар
4	2016 оноос хойш түрээсийн гэрээ цуцлагдсан нийт өрхийн барьцаа хөрөнгийг буцаан олгосон эсэх, авлагыг барагдуулсан эсэхэд хяналт шалгалт хийх	II улиралд	Хамааралтай алба газар хэлтэс
5	Түрээслээд өмчлөх гэрээтэй 919 иргэний барьцаа хөрөнгийн бүртгэл, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих	II улиралд	Хөрөнгийн удирдлага, ашиглалтын газар
6	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгийн бүртгэл тооцоо, хадгалалт хамгаалалтад хяналт шалгалт хийх	III улиралд	Санхүү, бүртгэлийн газар
7	Хөдөлмөрийн тухай хууль болон хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх	IV улиралд	Захиргаа удирдлагын газар
8	Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хэрэгжилт болон цалин хөлсний бүртгэлд хяналт шалгалт хийх	IV улиралд	Санхүү, бүртгэлийн газар
9	Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллагуудаас хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг таслан зогсоох, акт албан шаардлага зөвлөмжийн биелэлтийг хангуулах төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтэд хяналт тавих	I-IV улиралд	Хамааралтай алба газар хэлтэс
10	Гүйцэтгэх удирдлага болон иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх	Тухай бүр	